

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2020.03.27, №11 (140)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№520

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ТАХЛЫН ЦАГИЙН НАЙР БА МОНГОЛ МАДУРО



НИЙТЛЭЛ

Г.Нарантуяа
Олон улсын эрх зүйч (PhD),
Австралийн Үндэсний Их
Сургуулийн зочин судлаач

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫГ

Эсэргүүцэхийн учир

Ерөнхийлөгчийн засаглал монголд тохирохгүй, хичнээн гайхамшиг байсан ч бид энэ тухай ярих шаардлагагүй. Учир нь харьцангуй их эрх мэдлийг, харьцангуй тогтвортойгоор нэг хүнд шилжүүлдэг ийм засгийг дарангуйлалд урвуулахгүйн тулд бат бөх, ул суурьтай хяналтын механизм ажилладаг. Тийм хяналт Үндсэн хуульт байгууламжаас илүү өргөн хүрээнд, нийгмийн мөн чанарт шингэж оршдог. Харин бидэнд тийм орчин нөхцөл, тийм хяналтыг хэрэгжүүлэх тэнхээ өнөөдөртөө лав байхгүй. Яагаад гэдгийг энд тайлбарлана. Үүний зэрэгцээ дэлхийн улс төрийн өнөөгийн уур амьсгал ч нэг хүний засаглал “буруу замаар будаа тээх” өндөр эрсдэлтэй байгааг харуулж байна.

V НҮҮРТ



Коронавирусийн цар тахал өнөөдөр дэлхийн 200 оронд тархаж, 536 мянган хүн халдвар авснаас 24 мянга нь нас барж, 124 мянга нь эдгэрээд байна. Цар тахлын халдвар Азид буурч, Европ ба Хойд Америкт эрчтэй тархаж байна. Хүн амаа урьдчилан сэргийлж, бэлтгэл, сахилга дэг журамтай байсан улс орнууд халдварын тархалтыг харьцангуй сайн хянаж, бэлтгэлгүй нь олон мянган иргэдийнхээ амь насыг алдаж, хүнд хатуу сорилттой тулгарч байна. Монгол улс эхнээсээ харьцангуй бэлтгэлтэй хандсан учир вирус Европоос ирээд тусгаарлагдсан 11 хүнд л одоогоор илэрлээ. Хойд хилийн хоёр боомт, нийслэл хотод өнөөдөр хоёр мянга гаруй иргэд хоёр долоо хоног тусгаарлалтанд байна. Мөн олон мянган иргэд яаж эх орондоо буцаж ирэх арга замаа хайсаар байна.

Монгол улс өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, хорио цээрийн дэглэм тогтоон, онгоц, галт тэрэг зэрэг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, зах, үйлчилгээний газруудаа тусгай хуваариар ажиллуулж, бүх шатны сургуулиудаа 4-р сарын 30 хүртэл хааж, сургалтаа цахимаар явуулж байна. Оны эхний хоёр сар хагаст нүүрсний экспорт зогсож, аж ахуйн нэгж байгууллагууд ажиллагсдаа цалинтай, цалингүй чөлөө өгч, боломжтой нь гэрээсээ ажиллаж байна. МҮХАҮТ-ын судалгаагаар одоогоор ААН, компаниудын гуравны хоёрын орлого буурсан, бараг талынх нь үйл ажиллагаа доголдсон, зогсоосон, гуравны нэг нь ажлын байраа цомхотгосон гарчээ. Төсвийн орлого арваад хувиар тасарч, гадаад худалдааны эргэлт багасч, эдийн засгийн өсөлт буурч байна.

Монголчууд коронавирустай тэмцэж байгаа шигээ эконвирустай үр дүнтэй, хариуцлагатай тэмцэх шаардлага гарлаа. Онцгой нөхцөл байдал, онцгой шийдвэр шаарддаг гэтэл...



МӨНГӨНИЙ ҮЛБЭГЭР БОДЛОГО

- ▶ Эдийн засгийн идэвх суларч, өсөлт нь буурч байна. Ийм нөхцөлд улс орнууд юуны өмнө мөнгөний бодлогоо зөөллөж, эдийн засагт эргэлдэж буй мөнгөний хэмжээгээ нэмдэг. Монголбанк бодлогын хүүгээ 1 хувиар бууруулж 10, арилжааны банкуудын заавал байлгах төгрөгийн нөөцийг 2 хувиар бууруулж 8.5 болгов. Эдийн засаг хэвийн, бага ч гэсэн өсөлттэй байгаа нөхцөлд мөнгөний энэ бодлогын үр дүн хагас жилийн дараа гарна. Гэтэл Монголд, хэзээ хорио цээр зогсож, эрэлт нэмэгдэх нь тодорхой биш байхад өндөр хүүтэй зээл авах компани гарахгүй учир, энэ бодлогын үр нөлөө сул юмаа.

Ийм нөхцөлд төсвийн бодлогоо тэлэх шаардлагатай. Эдийн засгаа бууралтанд (recession буюу бууралт нь эдийн засгийн өсөлт хоёр улирал дараалан хасах гарахыг хэлдэг) оруулахгүйн тулд төсвийн зардлаа нэмдэг. Хэрэв эдийн засгийн бууралт үргэлжилж уналт болвол (depression буюу уналт нь орлого огцом багасч, ажилгүйдэл ихээр өсөхийг хэлдэг) араасаа эхлээд санхүүгийн, дагаад эдийн засгийн хямрал дагуулдаг. Тийм учраас Монголд төсвийн зардлаа ядаж багасгахгүй, харин зардал, хөрөнгө оруулалтын чиглэлийг нь өөрчлөх шаардлагатай байна.

Гэтэл Сангийн сайд Ч.Хүрэлбаатар төсвийн тодотгол хийхгүй гэж удаа дараа мэдэгдэв. Засгийн газар төсөвт тодотгол хийхээс болгоомжилж буй нэг шалтгаан бол

2020 оны улсын төсөв угаасаа 2 ихнайд төгрөгийн алдагдалтай, орлого нь 11.7, зардал 13.8 ихнайд төгрөг байхаар батлагдсан. Төсвийн орлого одоо буураад байхад зардлыг тэлвэл алдагдал улам том болно. Ганц нөөц болох Ирээдүйн өв санд төвлөрүүлсэн 620 тэрбум төгрөг нь алдагдлыг нөхөхөд багадна.

Нөгөө нэг шалтгаан нь гурван сарын дараа болох УИХ-ын сонгууль. Их хурлын гишүүд тойргоо “услах” төсвийн хөрөнгө оруулалтаа зогсоохыг хүсэхгүй, тэгээд ч бүх сайд нь давхар Их хурлын гишүүн (ЕС-аас бусад нь) учир У.Хүрэлсүхийн Засгийн газар төсвөө тодотгохоос цэрвэсээр байна.

Гэтэл цар тахалтай тэмцэхийн тулд цаашдаа нэмэлт хөрөнгө улам их шаардагдана. Энэ нөхцөлд Монголын Засгийн газар Дэлхийн банк, Азийн Хөгжлийн банк зэрэг гадаадын хөгжлийн инстүүцээс хөнгөлөлттэй зээл, тусламж гуйх үлдэж байна. Эдийн засагтай харьцуулахад гадаад өр 2016 онд 90 хувь байсан бол эдүгээ 72 болж буурсан ч, дэлхийн хөрөнгийн зах дээр нэмж бонд гаргах боломж бага. Улсын валютын нөөц хасах байснаа 4.5 тэрбум ам. доллар болсон нь хөнгөлөлттэй зээл тусламж авах магадлалыг өсгөж байгаа юм. Харин зээл тусламж авбал тэр хөрөнгийг юунд яаж зарцуулахаас Монголын эдийн засгийн бууралт, уналтын хурдац ихээхэн хамаарах юм.

ГОЛ НЬ АЖЛЫН БАЙР БОЛОХООС УИХ ДАХЬ СУУДАЛ БИШ

COVID-19 цар тахлын уршгаар орон бүрийг нөмрөөд буй “эконовирус” нь тухайн улсын ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийг хоёуланг нь бууруулж байна. Өвчтэй болон амин чухал бус бизнесийн хүмүүс гэртээ байснаар, ажлын байрны нийлүүлэлт унаж байна. Эрэлтийг дэмжих боломжгүй учир, ядаж байгаа ажлын байрыг нэмж алдахгүйн төлөө төр засаг онцгой арга хэмжээ авах шаардлагатай. Нэмээд ядуу, хэт бага орлоготой иргэдийн наад захын хэрэгцээг дэмжих хэрэгтэй. Тийм ч учраас, зарим орны Засгийн газар аваагүй цалинг нь төрөөс олгох (Герман), иргэн бүртээ бэлэн мөнгө тараах (Хонгконг, Австрали, Канад) зэргээр эдийн засгаа дэмжиж байна. Цар тахал Азид энэ оны III, бусад тивд IV улирлаас л намжих төлөвтэй гэж олон улсад үзэж байна.

Гэтэл Монголын төр засаг ажлын байрыг авч үлдэх арга зам хайж, иргэд, бизнес эрхлэгчдэд татвар, зээлийн хөнгөлөлт үзүүлэх, цалингийн тодорхой хэсгийг нь төлөх гэх мэт санхүүгийн туслалцаа үзүүлэхийн оронд 2020 оны сонгуулийн синдромд ороод явчихлаа. Эрх

баригчид сонгуулиа товоороо (6-р сарын 24) явуулах нь хойшлуулж, эдийн засаг буурахыг хүлээснээс, өөрсдөд нь илүү олон суудал авчирна гэж тооцоолж байгаа бололтой. Уг нь хамгийн ухаалаг, энгийн шийдвэр бол цар тахлын цагаар сонгуулиа ядаж хэдэн сараар хойшлуулж, хэмнэсэн зардлаар нь эдийн засгаа дэмжих нь зохистой.

Намууд мөрийн хөтөлбөрөө уржигдар Аудитын газар өгчээ. Төрийн эрх барьж буй МАН нийгмийн даатгал төлдөг иргэн бүрийг орон сууцанд хамруулж, зээлийн хүүг бууруулна гэсэн бол, АН өрхийн дундаж орлогыг 3 сая төгрөгт хүргэнэ, иргэд өөрсдөө орон сууцтай болно гэжээ. “Та бидний эвсэл” (МАХН, Иргэний Зориг Ногоон нам, Монголын Уламжлалын Нэгдсэн нам) иргэдийн дундаж цалинг 5 сая төгрөгт хүргэх гэнээ. Монголын төрийг ийнхүү ээлжит, дуудлага худалдаандаа орууллаа. Уг нь ардчилсан, чөлөөт эдийн засагтай оронд дундаж цалинг улс төрчид биш, хөдөлмөрийн бүтээмж, эрэлт хэрэгцээ өөрөө тогтоодог.



▶ Намууд цалин, мөнгө, хувьцаа амлаад ирэхээр, хэн ялсан нь ичсэндээ том том зээл тавьж, улс орноо өрөнд оруулдаг. 2008 оны сонгуульд АН эрдэнийн хувь-1 сая төгрөгийн хувьцааг иргэн бүрт эзэмшүүлнэ, одоогийн МАН (тухайн үед МАХН) эх орны хишиг-1,5 сая төгрөг иргэн бүрт өгнө гэж тус тус амласан. Сонгуулийн дараа эвслийн Засгийн газар байгуулагдаж төрийн өмчийн Таван толгой компаниар гадаадаас том зээл авахуулж,

иргэдэд тараасан бөгөөд тэр өрийг нь олон жилийн турш төсвөөс буюу татвар төлөгчдөөс төлсөн дөө.

Хорвоо ертөнц дээр цар тахал, үхэл зовлон ярьж уй гашуу болж байхад Монголд харин их хурлын “ашигтай” сэнтийг “орондоо орох завгүй олзлолдон булаалдахаар” зэхэж байна. Монголд “Тахлын цагийн найр” (Пир во время чумы. А.С.Пушкины зохиол.1830) айсуу.

2020.03.25

POST SCRIPTUM:

Энэ нийтлэл яг хэвлэлтэнд шилжих агшинд Ерөнхийлөгч Х.Баттулгын уриалга гарлаа. Ерөнхийлөгч COVID-19-ын тархалтыг бодитой үнэлж, зургаан зүйлийн арга хэмжээ авахыг уриалжээ. Эхний таван санал нь үнэхээр чухал бөгөөд миний дээрх нийтлэлд яаж хийхийг нь ч дурдсан байгаа. Харин “төрийн удирдлагыг төвлөрүүлэх” 6-р саналыг би огт дэмжихгүй байна.

COVID-19-тэй тэмцэх ажлыг Засгийн газар амжилттай сайн гүйцэтгэж байгаа шигээ эконовирустай амжилттай тэмцэж, таны эхний таван саналд туссан бүх арга хэмжээг авч явуулж чадна гэж итгэж байна. Харин түүнийг хийх эрч хүчийг нь сулруулж, төрийг хоёр удирдлагатай болгохгүй байхыг танаас хүсч байна. Дашрамд хэлэхэд та шинэ жилийн мэндчилгээгээрээ “бүх тэтгэврийн зээлийг тэглэсэн нь Засгийн газраа дарамталж, Хөгжлийн банкнаас эхлээгүй уурхайн, зараагүй баяжмалыг барьцаалан бонд гаргуулсан нь эдийн засгийг эрсдэлд оруулж, гадаад өрийг төлөх биш нэмэхэд хүргэж байгаа. Тэр 770 тэрбум төгрөгийг харин энэ вирустай тэмцэхэд гаргасан бол хичнээн их ажлын байрыг хамгаалж үлдэх байлаа.

Монгол улсын Гүйцэтгэх засаглалын тэргүүн нь Ерөнхий сайд, Ерөнхийлөгч биш гэдгийг танд сануулах цаг боллоо. Та төмөр зам тавьдаг, сум тохижуулж, дагуул хот барьдаг субъект биш. Энэ бүхнийг Засгийн газраар хийлгүүлэхийг танаас хүсч байна. Оросын хамгийн том газрын тосны Роснефть компаниас авсан 10 сая долларын хандивын тайланг сонгогчиддоо тайлагнахыг

шаардаж байна. Аудитын тайлантай цуг. Ардчилсан Монголын иргэд бид Ерөнхийлөгчөөрөө аж ахуйн ажлыг гадаадын хөрөнгөөр хийлгэмээргүй байна.

Та хүнд цагт эв нэгдэлтэй байхыг уриалжээ. Та Монголчуудын эв нэгдлийн бэлгэ тэмдэг, баталгаа учир өөрөөсөө эхлэж эв нэгдлийг бэхжүүлэхийг иргэд чинь хариу уриалж байна. Таны тэмцэж дуусгахыг амалсан авлига чинь улам томорсоор байна. Та Ерөнхийлөгч болсноос хойш авлигатай тэмцэх жүжгийн зарим гол дүрүүд өөрчлөгдсөн болохоос жүжиг яг хэвээрээ үргэлжилсээр байна. Том төслүүд чинь нууцаар явдаг болж байна.

Ерөнхийлөгч танд, гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг булаацалдахгүй байхыг зөвлөж байна.

Тэр жил Венесуэль улсын Ерөнхийлөгч эдийн засгийн онцгой дэглэм гэгчийг тогтоож Их хурлаа хүчингүйд тооцоод, бүх эрх мэдлийг гартаа авсан. Хориод жилийн дараа, дэлхийн хамгийн том газрын тосны нөөцтэй орны иргэд гуйлгачин болж, жорлонгийн цаас ч үгүй, хоол ч үгүй, бие биенээ дээрэмдээд сууж байна.

Монгол улс бол Парламентын засаглалтай улс, түүгээрээ ч ганц удирдагчтай хөрш орнуудаасаа ялгаатай. Зөвхөн Парламентын засаглалтай оронд нэг хүн биш нийт иргэд нь шийдвэр гаргадаг. Энэ бол Монголын тусгаар тогтнолын баталгаа.

УИХ-ын сонгуулийг цар тахалын ид тархалтын үед биш, намжиж дарагдах 9-р сард хийгээд л урагшаа явах нь зөв шүү.

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN



НИЙТЛЭЛ

Г.НАРАНТУЯА

Олон улсын эрх зүйч (PhD), Австралийн
Үндэсний Их Сургуулийн зочин судлаач

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫГ Эсэргүүцэхийн учир

Ерөнхийлөгчийн засаглал монголд тохирохгүй, хичнээн гайхамшиг байсан ч бид энэ тухай ярих шаардлагагүй. Учир нь харьцангуй их эрх мэдлийг, харьцангуй тогтвортойгоор нэг хүнд шилжүүлдэг ийм засгийг дарангуйлалд урвуулахгүйн тулд бат бөх, ул суурьтай хяналтын механизм ажилладаг. Тийм хяналт Үндсэн хуульт байгууламжаас илүү өргөн хүрээнд, нийгмийн мөн чанарт шингэж оршдог. Харин бидэнд тийм орчин нөхцөл, тийм хяналтыг хэрэгжүүлэх тэнхээ өнөөдөртөө лав байхгүй. Яагаад гэдгийг энд тайлбарлана. Үүний зэрэгцээ дэлхийн улс төрийн өнөөгийн уур амьсгал ч нэг хүний засаглал “буруу замаар будаа тээх” өндөр эрсдэлтэй байгааг харуулж байна.

Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжигсэд АНУ-ын тогтолцоог шагшин магтах аж. Гэхдээ тэд мөсөн уулын зөвхөн оройн хэсгийг харжээ. Суурийг нь ойлгохын тулд түүх ярих хэрэгтэй болно. АНУ-ын төрийн тогтолцоо зөвхөн Үндсэн хууль батлагдсанаар бий болоогүй юм. Тэр засаг, тэрхүү нийгмийн мөн чанарыг ойлгохын тулд наад зах нь 1066 онд Нормандчууд Английг эзлэж, газрыг нийгмийн зэрэг зиндаа харгалзан эзэмшүүлдэг түрээсийн тогтолцоо буюу феодализмийг бий болгосноос эхлэж харах учиртай. Энэ цаг үеэс АНУ-ын төрийн тогтолцооны өвөг болох Английн орчин үеийн төр, эрх зүйн тогтолцоо бүрдэж эхэлсэн.

Тооны хувьд цөөхөн, хүч багатай боловч дасан зохицох чадвар сайтай Нормандчууд Английг засаглахдаа шинээр захиргааны байгууллага, хууль цаазыг бий болгохгүйгээр Англи-Саксоны төрийн байгууллагуудын хуучин суурийг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрчилсөн юм. Англид эзэн суухад Нормандчуудын түшиц нь үнэнчээр дагахаа илэрхийлж, газрын эзэд болсон Англи-Саксоны язгууртнууд, түшмэлүүдээс илүүтэйгээр эзэд, ноёдынхоо шударга бус байдалд гоморхсон ард олон байв. Нормандын хаадууд ардуудад ойрхон байж, гомдол, маргааныг нь өөрийн биеэр, харьцангуй шударгаар (ижил тохиолдлуудыг адил шийдэж) шийдвэрлэх замаар засаглах эрх, нөлөөгөө бэхжүүлж байсан нь улмаар парламентад ёс, нийтийн эрх зүй (common law) бий болох нөхцлийг бүрдүүлжээ. Энд

Английн эрх зүйн тогтолцооны түүхийг хүүрнэвэл бас чухал дүр зураг харагдах боловч уншигч таныг залхаахгүйн тулд феодалийн тогтолцоо, багахан орон зайд нийгэмшиж амьдардаг олон хүн, эзэн хааны ард олонд ээлтэй байх шаардлага, тэдгээрээс үүдэлтэй зуун дамжиж хөгжсөн нарийн, төвөгтэй хууль эрх зүйн тогтолцооны үр дүнд хууль, дэг журмыг эрхэмлэх сэтгэлгээ Англичуудын соёлын ДНХ-ийн нэг хэсэг болсон гээд орхиё.

Ямар ч эрх мэдэл ялзрах хандлагатай байдаг¹ тул эрх мэдлийг хязгаарлах дэвшилтэт институтээ (парламент ба шүүх), тогтвортой хуулиа тэдгээрийг төрүүлсэн Нормандын угшлын хаадын дур зоргоос хамгаалах шаардлага цагийн эрхээр Англичуудад бий болж байв. Ийнхүү 1215 онд Магна Карта (Magna Carta)², 1689 онд Эрхийн Билл (Bill of Rights)³, 1701 оны Эвлэрлийн тухай хууль (Act of Settlement)⁴ батлагджээ. Хязгаартай эрх мэдэл, маргааныг ашиг сонирхлоос ангид шийдвэрлэхийн чухлыг зүрх, тархиндаа бат ойлгосон Англичуудын туршлага таван зууныг туулан сая цаасан дээр буув. Өнөөдөр ч Англид эртний эдгээр баримт бичгээс өөр бичигдмэл Үндсэн хууль байдаггүй. Австралийн төрийн тогтолцоонд хамгийн их эрх мэдэлтэй субъект бол Ерөнхий сайд. Харин Ерөнхий сайд гэсэн үгийг Австралийн Үндсэн хуулиас эрээд та олохгүй. Тэнд гүйцэтгэх засаглалын ажил хуулиар гэхээсээ уламжлал, сэтгэлгээ, соёлоор зохицуулагддаг.

ОДОО АНУ-ЫН ТУХАЙД

1606 онд нэгдүгээр Жэймс хаан Плаймауд, Лондон компаниудад шинэ тивд байнгын колони байгуулах зөвшөөрлийг өгснөөр Америкийн колончлол эхлэв. АНУ байгуулагдах хүртэл 180 орчим жилд Английн 13 колони өлгий нутгаасаа өвлөсөн засаг захиргаа, эрх зүйн үндсэн дээр харьцангуй бие даан оршиж байлаа. Гэвч феодалийн тогтолцооны утгыг алдуулсан шинэ тивийн өргөн уудам, эзэнгүй газар, харьцангуй эрх чөлөө зэрэг нь өдөр тутмынх нь амьдралд нөлөө багатай боловч хөдөлмөрийнх нь үр шимийг хуу хамдаг хааны засгийг эсэргүүцэх сэдлийг колонийн иргэдэд төрүүлсээр байв. Өөрийн эрхээр амьдарч болох байтал яагаад эзэн хааны боол хэвээр үлдэх гэж? энэ асуултын хариулт болж “The American creed” буюу “Америк маягийн итгэл үнэмшил” колонийн жилүүдэд боловсорсон юм. Эрх чөлөөний хүсэл тэмүүлэл хувьсгалд (1765-1783) хүргэв, дайны дараа Үндсэн хууль (1788) батлагдаж, АНУ мэндлэв. Энэ тухай АНУ-ын хоёр дахь Ерөнхийлөгч Жон Адамс “Америкийн хувьсгал эхлээд хүмүүсийн оюун санаа, зүрх сэтгэлд гарсан юм” хэмээн бичиж үлдээсэн нь бий.

АМЕРИК МАЯГИЙН ИТГЭЛ ҮНЭМШИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Товчхондоо, чөлөөт байдал (liberty), тэгш байдал (equality), бие даасан, хараат бус хувь хүн байх (individualism) болон өөрсдөө засаглах (self-government) гэсэн ойлголтуудыг Америк итгэл үнэмшил багтаадаг⁵. Чөлөөт байдал нь дарангуй төрөөс ангид байхыг, тэгш байдал нь нийгмийн бүх гишүүд үнэ цэнэ, эрхийнхээ хувьд адил тэгш байхыг, хувь хүн байх нь эдийн засгийн хувьд хараат бус, орон зай нь халдашгүй байхыг, өөрсдөө засаглах нь төрийн бодлогод үг, үзэл бодлоо тусгуулах боломжтой байх нөхцлүүдийг шаарддаг. Эзэн хаант засгийн дарангуйллыг эсэргүүцэж үүссэн улс төрийн олонлог учраас эрх мэдэлд болгоомжтой хандах, түүнийг хянах соёл Английн колони асан бусад улсуудынхаас ч өндөр. Ийм соёл, сэтгэлгээний суурин дээр өнөөдрийн АНУ өндийсөн. Нийтлэг үндэс угсаагүй энэ улсын иргэдийг эдгээр итгэл үнэмшил л Америк хүн болгодог. Соёл, спортын үйл ажиллагаа, орон нутгийн дунд сургуулийн хурал цуглаанаас эхлээд төрийн том ёслолоор үйлдэгддэг зан үйл бүхэлдээ эдгээр итгэл үнэмшлийг америкчуудын тархи, зүрхэнд суулгасаар ирсэн.

АНУ-ын Үндсэн хуулийг боловсруулах, холбооны засгийн бүтцийг зураглахад америк итгэл үнэмшил “алтан гадас” болж байв. Тийнхүү бүтээсэн засаг нь мөн эдгээр итгэл үнэмшлийг биежүүлэхэд хөтөч болох учиртай байлаа. Мэдээжийн хэрэг тийм архитектурыг холоос хайх шаардлага АНУ-ын Үндсэн хуулийн эхийг боловсруулагчдад байгаагүй. Төрийн эрх мэдлийг хуваарилах онолын Библи болох “Хуулиудын амин сүнс”-ийг Барон де Монтескье английн төрийн тогтолцооноос ургуулан бичсэн гэх юм билээ. Хэдийгээр америкчууд эрх чөлөөг максимум байдлаар хамгаалж чадах засгийг зураглахыг хичээсэн ч гарал үүслээсээ хол явж чадаагүй юм гэсэн санааг судалгааны нэг бүтээлээс дээх нь үед уншсан санагдана. Эзэн хааныг ерөнхийлөгчөөр сольсон нь харьцангуй уламжлалт хандлага боловч түүнийг хянах төрийн байгууллагуудын цогц тогтолцоог хуульчлан бүрдүүлсэн нь тухайн үедээ маш том дэвшил байсан. Гэвч тэр цагаас хойш 250 шахам жил өнгөрчээ.

**ХҮЧТЭЙ ЕРӨНХИЙЛӨГЧ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛДЭГ ГҮЙЦЭТГЭХ
ЗАСАГЛАЛЫГ ПАРЛАМЕНТ, ШҮҮХ, ХУУЛИАС ГАДНА НИЙГЭМ
НЬ, СОЁЛ НЬ, СЭТГЭЛГЭЭ НЬ ХЯНАДАГ ЮМ. ХЯНАХ ЁСТОЙГОО
УХАМСАРЛАСАН ОЛОН НИЙТ, ХЯНАГДАХ ҮҮРГЭЭ ОЙЛГОДОГ
УЛС ТӨРЧИД ТЭР ТОГТОЛЦООГ АМИЛУУЛДАГ.**

Нүдэнд харагдахгүй, хүний үйлдлийг тэр бүр яв цав тодорхойлохгүй ч соёл, хандлага, дадал хэмээгч зүйлс зөв, бурууг шүүх нийгмийн хэмжүүр болж, аливаа сонголтын учир шалтгаан болдог. Америк итгэл үнэмшил АНУ-ын төрийн бодлогыг хэрхэн залдгийг олон жишээнээс харж болно. Европын чөлөөт, ардчилсан дэглэмтэй улс орнуудтай харьцуулахад АНУ-ын нийгмийн халамжид зарцуулдаг төсөв харьцангуй бага, гэвч боловсролд зарцуулдаг төсөв нь их. Учир нь бусдын дэмжлэгийг авах зайлшгүй шаардлагатайгаас бусад үед хувь хүн өөрийгөө бүрэн хариуцах ёстой, харин хүн бүр амжилтад хүрэх тэгш боломжтой байх ёстой учраас чанартай боловсрол хүн бүрт хүртээмжтэй байх ёстой гэсэн нийгмийн итгэл үнэмшил эдгээр бодлогын цаана бий. Иргэний эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хөдөлгөөнүүд амжилтад хүрч, АНУ-г өөрчилж байгаагийн сэтгэлгээний суурь нь тэгш байдлын зарчим. Хүн бүр тэгш байх ёстой нийгэмд нэг хэсэг нь тэгш бус амьдарч байгааг эсэргүүцсэн тэмцлийг америкийн нийгмийн олонх нь итгэл үнэмшлээрээ дэмжсэн учраас байдал өөрчлөгдөж байгаа юм.

ХАРИН БИД ХЭН БИЛЭЭ?

Монгол мөрөөдөл ч юм уу, оюун санааны талаасаа бид хэн болох, хэн байхад тэмүүлэх ёстойг зааж зурсан итгэл, үнэт зүйлсийн томъёолол бидэнд байхгүй. Харин бид ямар соёл, сэтгэлгээ, дадалтай улс вэ гэдгийг эргэцүүлэхийг хичээсэн оролдлого хэдэн зуу биш юм гэхэд хэдэн арав бий⁶. Нэгэнт ихээхэн задгай, барьцгүй асуудал учраас зөвхөн энэ нийтлэлийн агуулгад хамааралтай соёл, оюун санааны асуудлыг л товчхон, бүдүүлэгдүү сануулъя. Бидэнд хуулийг эрхэмлэх, төрийн эзэн гэдгээ ухамсарлаж, эрх мэдлийг хянах, хувийн орон зайны халдашгүй байдлыг хамгаалах соёл, дадал, итгэл үнэмшил, хандлага бий юу? Бид олиггүйдээ биш, гагцхүү бид өөр түүхтэй, өөр орчинтой, өөр философийн нөлөө бидэнд хавьгүй их учраас оюун санааны тийм ДНХ маньд байхгүй. Байхгүй юу байхав, сүүлийн 30 жил бий болгохоор ядаж байна. Гэхдээ маш хэврэг.

Англиас төрсөн улс орнууд хэдэн зууны туршид өөрийн жамаар хөгжсөн соёл, сэтгэлгээний суурийг өвлөж, нүүдэллэн суурьшсан газрынхаа онцлог, үүссэн хөгжлийнхөө түүхээр нөхцөлдсөн өөр өөрийн өвөрмөц сэтгэлгээ, соёлыг бий болгосон. Угшил нэг боловч ондоошил бас их бий. Хамгийн гол нь тэдний соёл сэтгэлгээ органикаар хувьссан.

Харин? 20 дугаар зууныг Манжийн хамжлагаар эхэлсэн наш народ хувь заяаны эрхээр дэлхийн хоёр дахь социалист улс болов. Намын дарангуйллыг эцэслэх гэсэн олон нийтийн хүсэл, Зөвлөлт засгийн нөлөөг халах эрх баригчдын сонирхол нэгдэж, ардчилсан чөлөөт нийгмийг сонгов. Бидний соёл, сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл ганцхан зууны дотор гурван удаа огцом, эрс өөрчлөгдсөн.



Гэрэл зургийг зохиогч хэдэн жилийн өмнө нийгмийн сүлжээнээс татаж авч, хадгалсан болно. Зурагчны утга төгс илэрхийлэлд талархаж, бүтээлийг нь ашиглах зөвшөөрөл хүсч байна. Зөвшөөрөл өгөхөөс татгалзвал Дефакто газет сонин редакцтай холбогдоно уу.

- ♦ Улаанбаатарын гудамжинд Буддын сүм, социализмийн ёотон маягийн орон сууц, капиталист шилэн барилгыг давхцуулан харж болно. Үүний адилаар бидний оюун санаанд өнгөрсөн хийгээд өнөөдрийн үнэт зүйлс холилдон эмх замбараагүй оршиж байгаа.
- ♦ Их монголын эзэнт гүрнээс улбаатай төрийг дээдлэх үзэл, Буддын шашны хүлцэнгүй философи, намаас айж, даргыг шүтэж явсан социализмийн туршлага бидний ой санамжид амь бөхтэй бий.
- ♦ Уудам орон зайд нүүдэллэн амьдарч ирсэн, өдөр тутмын амьдралд нь төр, хуулийн оролцоо харьцангуй бага байсан учраас бидэнд хуулийг сахихын чухлыг чөмгөндөө тултал ойлгох туршлага байсангүй. Социализмийн үед даргын үг хууль, хууль харин гууль байв.
- ♦ Саяхныг хүртэл өмгөр эсгий гэртээ гурван үеэрээ шамбааралдан амьдарч ирсэн маниус хувийн орон зайн халдашгүй байдал манатай. Цөөхүүлээ учраас аймаг хошуугаараа хамаатан шахуу, танилын халуун нүүрний илчинд зүй ёс, хууль ёс хайлж урсах нь элбэг⁷.
- ♦ Багштай маргах нь битгий хэл, асуулт асуувал заримдаа бурууддаг сургуулийн хүмүүжилтэй бид харьцангуй эрх мэдэлтэй ганц бүдүүн даргатай болчихоод түүнийгээ улалзуулж барах уу? 45-аас дээш настай, социалист ухамсрын бүтээгдэхүүн байх өндөр магадлалтай дарга маань ард түмний үйлчлэгч гэдгээ гүн бат ухамсарлаад улалзаад, учирлаад зогсож байх болов уу? Ихээхэн эргэлзээтэй шүү. Одоогийн

овоо даруулгатай даргаасаа бид чинь хариуцаж байсан дэд бүтцийн төслүүдийнх нь тухай битгий хэл хань ижил нь хэн болохыг ч асууж чадахгүй л яваа туулайнууд шүү дээ. Уул шугамандаа төрийн тэргүүний гэр бүлийн амьдрал нийтэд ил байж, түмэн олон ямар хувь хүнд итгэж, удирдуулснаа хянадаг. Хүний албан дүр, гэрийн дүрээс өөр байх нь олонтаа. Аль алиных нь зах зухыг мэдэрч байж удирдагчаа бид арай дээр танина.

АНУ-ын төрийн архитектурыг магтах яахав. Тэр барилгын суурь, түүнийг барьсан материал нь бидэнд алга. Төвлөрсөн эрх мэдлээс үүдэн гарах эрсдлийг бид үүрч чадахгүй. Даахгүй байж, булуу хураахаа болих уу даа, хампаануудаа?

- ¹ 19 дүгээр зууны Английн улс төрч Лорд Актоны “Power tends to corrupt. Absolute power corrupts absolutely” буюу “Эрх мэдэл ялзрах хандлагатай байдаг, хязгааргүй эрх мэдэл найгүй ялзардаг” гэсэн алдарт ишлэлийг сануулав. Эрх мэдэлд хүрсэн хүний ёс зүй ихэвчлэн доройтдог гэсэн аксиоматик ойлголттой учир Англиас төрсөн улс орнууд сайн удирдагчийг хайхаас илүүтэй түүнийг хянах сайн тогтолцоо ажиллуулахыг зорьдог.
- ² Эзэн хааны эрх мэдлийг хязгаарласан хууль зүйн анхны баримт бичиг.
- ³ Улс төрийн эрх, парламентийн засаглалыг баталгаажуулсан баримт бичиг.
- ⁴ Английн хаан ширээг залгамжлагчийн талаарх маргааныг шийдвэрлэсэн энэ баримт бичгийн өөр нэг түүхэн ач холбогдол нь шүүхийн хараат бус байдлыг баталжуулсан явдал юм.
- ⁵ The American creed гэх агуулгыг улс төрчид, судлаачид янз бүрээр тодорхойлсон нь бий. Бусад хувилбартай харьцуулахад товч, тодорхой санагдсан тул Харвардын их сургуулийн профессор Том Паттерсоны хувилбарыг энд авлаа. АНУ-ын төрийн тогтолцоо, бодит нөхцөл байдлын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл профессор Том Паттерсоны www.edx.org онлайн сургалтын платформ дээр заадаг U.S Government хичээлийг судлахыг зөвлөө.
- ⁶ Баабар, Б.Цэнддоо, Д.Баярхүү, Х.Тэмүүжин нарын нийтлэл, бүтээлүүд бид хэн болох тухай олонтаа эргэцүүлдэг. Уянгын халил багатай, бодит байдалд ойр дүр зургийг тэд дүрсэлсэн санагддаг. Хамгийн сүүлд философийн доктор С.Одхүү “Монгол ментатитет” (2017) гэж ном гаргасан байна лээ.
- ⁷ Г.Дашрэнцэн гуайн “Манай сумын намууд” ёгт нийтлэлийг уншихыг хүсье. Та нулимсаа урстал инээнэ, гэхдээ ардчилсан институтүүд манай хөрсөнд хэрхэн мутацид орж болох тухай ёг хийсэн сэтгэгдэлтэй үлдэнэ.

Үндсэн хуульт байгууламж вакумд оршдоггүй, улс төрийн соёл, нийгмийн сэтгэлгээгээр амилдаг гэдгийг сануулаад, эрх мэдэлд хяналт тавих, эрх мэдэлтэн нь хянуулах дадал бидэнд харьцангуй хэврэг болохыг өгүүлсэн. Товчхондоо, уншигч таныг дотогшоо эргэцүүлэхийг санал болгосон. Энэ хэсэг харин гадагшаа харах юм.

Хэзээнээсээ ямар ч хүчирхэг улс орон туйлын дангаар, хэнээс ч хамааралгүй оршиж байсангүй. Түүхийн туршид хэвлэх үйлдвэр, уурын тэрэг, интернет зэрэг технологиос эхлээд шашин, үзэл санааны урсгалууд, улс төрийн үзэгдлүүд газрын зураг дээрх хил

хязгаарыг даанч нэг тоолгүй улс хооронд зорчиж, нийгмийн мөн чанарыг өөрчилсөөр ирсэн. Эд баялгийг хэт төвлөрүүлсэн цөөн хөрөнгөтний эсрэг ядуу тарчиг ажилчин анги Европын зүрхэнд тэмцэл өрнүүлсэн нь тусгаар тогтнолын тэмүүлэлтэй сүлэлдэн талын Монголд социалист улсыг төрүүлж байв. Намын дарангуйлал, үзэл бодлын цензур, үр ашиг багатай эдийн засгийг шүүмжилж, зүүн Европт сэвэлзсэн “салхи” мөн л үндэсний ашиг сонирхолтой нэгдэж, улаан Монголыг цэнхэр болгосон. Дэлхийн улс төрийн цаг агаар дахин өөрчлөгдөж байна, гэхдээ энэ удаа бидэнд ашиггүй байдлаар.

.....

**ДАРАНГУЙЛАЛ ГЭЖ НЭГ ХҮНИЙ
ГАРТ ТӨВЛӨРСӨН ХЯНАЛТГҮЙ
ЭРХ МЭДЭЛ, ОЛОН УРГАЛЬЧ
ҮЗЭЛ ХУМИГДСАН БАЙДЛЫГ
ХЭЛЖ БАЙНА**

.....

Готенбургийн их сургуулийн Анна Лурман, Стаффан Линдберг нарын энэ онд нийтэлсэн шинжилгээний өгүүлэл судлаачдын анхаарлыг татаж байна¹. Тэд 1900-2017 онд дэлхийн 109 улсад өрнөсөн хаалттай нийгэм, дарангуй засгийг бий болгох 217 удаагийн оролдлогод шинжилж, дарангуйллын гурав дахь давалгаа бодитоор бий

болсныг харуулжээ. Дарангуйлал гэж нэг хүний гарт төвлөрсөн хяналтгүй эрх мэдэл, олон ургальч үзэл хумигдсан байдлыг хэлж байна. Тэдний судалгаагаар дарангуйллын эхний давалгаа 1926-1942 онд, хоёр дахь давалгаа 1961-1977 онд явагдсан бол гурав дахь давалгаа 1990-ээд оны эхэн үеэс Орос, Армен, Беларусаар эхлэж, одоо эрчээ авч байгаа аж. Ухаандаа Стэнфордын Фукуяама профессор хүн төрөлхтөн чөлөөт ардчилсан дэглэмийг сонгож, түүх төгссөнийг зарлаж дуусаагүй байхад өөр нэг хоржоонтой тоглоомыг түүх эхлүүлж байсан гэсэн үг².

Ардчиллаас илт ухарсан Венесуэл, Итали, Турк, Унгар, Польш, Филиппин төдийгүй Энэтхэг, Япон, АНУ-д одоо өрнөж буй мөн чанар, үр дагаврыг дүгнэхэд эртдэх үйл явцууд судлаачдын анхаарлын гадна мэдээж байгаагүй. Харин эдгээр үзэгдлүүд тухайн улсын дотоодын, харьцангуй дангаар шинжтэй юу, эсвэл харилцан хамааралтай юу гэдэг нь маргаан дагуулж байсан юм. Дарангуйллын гурав дахь давалгаа бодитой болохыг олон эх сурвалж дуу нэгтэй хэлэх боллоо. Энэ үзэгдэл нэг бүс нутгийн улс орнуудад төсөөтэй хэлбэрээр өрнөж³ байгаа болон авторитар удирдагчид хэрхэн бие биеэсээ суралцдагийг зурагласан өгүүлүүд ч хэвлэгдэж байна⁴.

Лурман, Линдберг нарын судалгааны өөр нэг чухал үр дүн нь давалгааны мөн чанартай холбоотой юм. Дарангуйллын нэг, хоёр дахь давалгаанд төрийн эрхийг зэвсгийн хүчээр булаах тохиолдол олон байв. Өнгөрсөн зуунд Аргентин, Бразил, Доминикан, Гана, Грек, Гуатемала, Нигер, Пакистан, Перу, Тайланд, Турк, Уругвайд цэргийн болон төрийн эргэлт хийж, илт хууль бус

аргаар ардчиллыг “нүд аниулж” байсан. Харин энэ удаад ардчилсан сонгуулиар төрийн эрхийг олж авсан удирдагчид хууль зүйн аргаар эрх мэдлээ дархлах үйл явц зонхилж байна. Гурав дахь давалгаанд хамааруулж тэдний шинжилсэн дарангуйлал тогтоох 75 оролдлогын 70 орчим хувь нь ардчилсан институциудыг аажмаар мэрг, сулруулах замаар өрнөж байгаа аж. Энэ дүгнэлт нь өмнөх жилүүдэд хийгдсэн олон судалгааны таамаглалууд, түүний дотор Харвардын профессорууд Стивен Левицки, Данейл Зиблатт нарын ихэд алдаршиж буй номын ажиглалтыг статистикийн аргаар баталгаажуулжээ⁵.

Төрийн эрхийг хүчээр булаах нь эрсдэл өндөр, олон нийтийн эсэргүүцэл, гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын шахалтаар бүтэлгүйтэх нь олонтаа. Тухайлбал, 2016 онд сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй Гамбийн ерөнхийлөгч Yahya Jammeh-ийн үйлдэл хөрш орнуудын дургүйцлийг төрүүлж, түүнийг эх орноо орхин явахад хүргэсэн. Сонгуулийн илт булхай нийтийг хамарсан үймээн самуун, өнгөт хувьсгалуудыг өдөөж байв. Харин сонгогдсон удирдагчид хяналтын институциуд (шүүх, бусад хараат бус байгууллагууд)-ыг ганхуулах, хэвлэл мэдээллийг хянах, иргэний нийгэм, улс төрийн намууд, сөрөг хүчнийг хязгаарлах зэргээр илт биш, хуулиар халхавчилж эрх мэдлээ зузаатгах нь удаан боловч эрсдэл багатай.

Ихэнхдээ цаг улирал бодитоор хэзээ солигдсоныг бид анзаардаггүй. Ганц нэг хүйтэн өдөр, намрын нар, бороотой саарал тэнгэр, дахиад нар, цас. Намар үнэндээ хэзээ дууссаныг, өвөл хэзээ эхэлснийг хэлэх үргэлж амархан байдаггүй. Яг үүн шиг

ардчилал хэзээ алга болсныг ийм тохиолдолд хэлэхэд хэцүү. Учир нь хулгайлагдсан ардчиллын үед шүүх, парламент оршиж, сонгууль явагдаж байвч мөн чанартаа эрх мэдэлд хяналт байхгүй болж, сөрөг хүчний амьгүй намууд моргид хэвтэж байдаг.

Европ, Латин Америкийн улс орнуудад ардчиллыг хумих үйл явцыг 15 жил судалсан Левицки, Зиблатт нар дарангуйлал тогтоох үйл явц хэрхэн явагдаж буйг ийнхүү тайлбарлажээ⁶. Эрх мэдлээ дархлахаар шийдсэн удирдагч, мэгдэж хоцорсон ардчилсан институциудын хоорондын улс төрөөс үүссэн урьдчилж таамаглахын аргагүй үйл явцуудын үр дүнд ардчилал хумигдаж байгаа аж. Энэ үйл явц ихэнхдээ үгээр эхэлдэг. Венесуэлийн Уго Чавес өрсөлдөгчдөө “арчаагүй олигархууд”, шүүмжлэгчдээ “дайснууд”, “урвагчид” хэмээн цоллож байв. Перугийн Алберто Фужимори өрсөлдөгчдөө хар тамхины наймаачид, терроризмтой холбож, Италийн Силвиа Берлускони өөрийнх нь эсрэг шийдвэр гаргасан шүүгчдийг коммунизмтай хамаатуулж, Туркын Режеп Тайип Эрдоган сэтгүүлчдийг терроризмийг дэмжигчид хэмээн буруутгаж байжээ. Энэ мэт үгс хэдийгээр бодит үр дагаваргүй, хоосон сонсогдовч нийгмийг талцуулж, үл итгэсэн, үзэн ядсан, тайван бус уур амьсгалыг бий болгодог.

Дараагийн нийтлэг дайралт шүүх, хуулийн байгууллага, тагнуул, татвар зэрэг хараат бус хяналтын механизмууд руу чиглэдэг. 2010 оноос хойш Унгарын ерөнхий сайд Виктор Обран прокурор, аудит, омбудсмен, статистикийн байгууллага, Үндсэн хуулийн шүүхийг өөрийн хүмүүсээр

бүрдүүлсэн. 2015 онд Хууль ба шударга ёсны нам Польшийн төрийн эрхинд дахин гармагцаа Үндсэн хуулийн трибуналийг өөрийн болгов. 2005-2007 онд Үндсэн хуулийн трибунал тус намын эсрэг хэд хэдэн шийдвэр гаргаж байсан юм. Перу, Венесуэл, Турк ч үүнийг давтсан.

Хараат бус хяналтын байгууллагуудыг гартаа оруулсан эрх мэдэлд шунагч цаашлаад нөлөө бүхий эсэргүүцэгчидтэйгээ ажилладаг. Сөрөг хүчний улс төрчид, тэднийг санхүүжүүлэгч бизнесийнхэн, хэвлэл мэдээлэл, олон нийтэд нэр хүндтэй шашин, урлагийн зүтгэлтнүүд энд багтана. Албан тушаал амлаж урвуулах, худалдан авах нь түгээмэл боловч хүчхэрэглэхтохиолдолбасцөөнгүй. Малайзын ерөнхий сайд Мохамед Махатир “өөрийн” цагдаа, шүүхээр зэвсэглэн улс төрийн өрсөлдөгч Анвар Ибрахимийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан хэрэгт буруутгаж, 9 жил хорих шийтгэл оногдуулж байв. Венесуэлийн сөрөг хүчний удирдагч Леонардо Лопез хүчирхийлэл өдөөсөн хэргээр шийтгэгдэж байв. 2011 онд Эквадорын ерөнхийлөгч Рафеал Корреа “El Universo” сонинг дарангуйлагч гэж гүтгэсэн хэмээн буруутгаж, 40 сая долларын торгуульд унагав. Туркт Эрдоган “Dogan Yayin” мэдээллийн конламератыг татварын хэргээр дампууруулж, Орост Путин NTV, ORT-ын амыг барьжээ. Сөрөг хүчнийг санхүүжүүлэхгүй байх тухай Путиний сануулгыг хүлээж аваагүй, “том толгой” Ходоровскийд юу тохиолдсоныг та санах байлгүй.

Дарангуй улс төрчийн дараагийн бай нь тоглоомын дүрмийг өөрчлөх гэнэ. Сонгуулийн хуулиуд, Үндсэн хууль овоо

хараанд орно гэсэн үг. Малайзын парламентийн 2004 оны сонгууль, Унгарын парламентийн 2014 оны сонгуулиуд эрх баригч намууд давуу байдлаа ашиглан, хуулийг өөрт ашигтайгаар өөрчилж эрх мэдлээ зузаатгасны жишээ. Хяналтын байгууллагуудыг өөрийн хүмүүсээр бүрдүүлэх, сөрөг хүчин, шүүмжлэгчдийг ил, далд хумих болон ердийн хуулиудыг өөрчлөх зэргийг олон нийт тэр бүр анхаардаггүй. Харин Үндсэн хуульд гар дүрэхэд том шалтаг хэрэгтэй. Эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг, террорист халдлага, авлига зэрэг нийгмийн асуудал, бэрхшээлүүд энэ хэрэгт олз болно. 1972 оны 7-р сард Маниллад болсон бөмбөгдөлтүүдийг 1973 онд 2 дахь бүрэн эрхийн хугацаа нь дуусах байсан Фердинанд Маркос олзолж онц байдал зарласан, Үндсэн хуулиа өөрчилж эрх мэдлээ дахин 14 жил дархлаж байв.

2015 оны 6-р сард болсон Туркын парламентийн сонгуульд Ерөнхийлөгч Эрдоганы Шударга ёс, Хөгжлийн нам (АКР) ялагдсан боловч ISIS-ын террорист халдлагууд, үүнээс улбаатай үүссэн нийгмийн айдсыг далимдуулан ээлжит бус сонгууль зарлаж, эхний сонгуулиас хойш тавхан сарын дараа АКР парламентийн олонх болов. 2016 онд болсон цэргийн эргэлт хийх оролдлого Эрдоганд онц байдал зарлах боломж олгов. Энэ үеэр мэдээллийн хэд хэдэн агентлагууд хаагдаж, 50 000 орчим хүн, түүний дотор хэдэн зуун шүүгч, прокурор, Үндсэн хуулийн шүүхийн 2 шүүгч, 144 сэтгүүлч баривчлагдсан. Хамгийн хорлонтой нь 2017 оны 4-р сард Үндсэн хуулиндаа өөрчлөлт хийж, ерөнхийлөгчид тавих хяналтуудыг бүрмөсөн үгүй хийв.

Магтаад байгаа Америкийн

маань улс төрчид, судлаачид, олон нийт ерөнхийлөгчийнхөө үйлдлийг түгшин ажиглаж байна. Дарангуй удирдагчийн дөрвөн шинжийг Трамп ерөнхийлөгч харуулж буйг улс төр судлаачид тэмдэглэх ажээ. Ардчилсан төрийн дүрэм журмыг сахих эрмэлзэл сул, өрсөлдөгчийнхөө хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрдөггүй, асуудлыг хүчээр шийдэхийг дэмжих хандлагатай, сөрөг хүчин, шүүмжлэгчдийнхээ дуу хоолойг боомилох сонирхолтой гэсэн шинжүүдийг тэд нэрлэж байна. Ийм ерөнхийлөгч сонгогдоход хүргэсэн тогтолцооныхоо цоорхойг тэд дүгнэн ярилцаж байна. Эрх мэдлийг хязгаарлах соёл, өрсөлдөгчөө хүлээн зөвшөөрөх (mutual tolerance) болон тогтолцоог ганхуулахаас зайлсхийх (institutional forbearance) улс төрийн бичигдээгүй дүрмүүд⁷ төдийгүй ерөнхийлөгчид нэр дэвшигчийг тодруулахад хамгийн чухал үүрэгтэй намуудын филтер нь хаана доголдсоныг тэд яг одоо шүүн тунгааж байна. АНУ-ын төрийн тогтолцооны бодит байдлыг судлах, ойлгоход үүнээс тохиромжтой цаг үгүй мэт.

АНУ-ын тогтолцоо эрх мэдлийг хязгаарлах төгс жор биш. Колончлолын дараах Латин Америкийн улсуудын ихэнх нь АНУ-ын Үндсэн хуулийг хуулсан. Тэд Америк маягийн ерөнхийлөгч, хоёр танхимтай парламент, шүүх, зарим нь бүр сонгогчдын коллеги, холбооны тогтолцоог нь хүртэл авсан. Гэвч тэдний ихэнх нь иргэний дайн, дарангуй засгийн горьг амссан. Заалтуудынхаа 2/3-ыг АНУ-ын Үндсэн хуулиас шууд хуулсан Аргентиний Үндсэн хууль (1853) 1930, 1943 оны цэргийн эргэлтүүд, Пероны түрэмгий, хяналтгүй засгаас сэргийлж

чадаагүй. Америкийн колони байх үедээ боловсруулж, АНУ-ын Сенатаар батлагдсан Филиппиний Үндсэн хууль (1935) цагтаа “чөлөөт ардчилсан засгийн сурах бичиг” гэгдэж байлаа. Гэтэл төрийн эрх мэдлийг хуваарилж, хүний эрхийг тунхаглаж, ерөнхийлөгч хоёр бүрэн эрхийн хугацаанд ажиллахыг баталгаажуулсан энэ Үндсэн хууль ерөнхийлөгч Маркосыг төрийн эрхэнд 21 жил суухаас сэргийлж чадаагүй юм. Маркосын Филиппин ямар байсныг нэг гүүглэдчихгүй юу даа.

Дэлхийн улс төрийн барометр төвлөрсөн эрх мэдэл хадуурах эрсдэл их байгааг харуулж байна. Тэр тусам нь бид парламентийн засаглалаа бэхжүүлэх ёстой, алдаагаа засахыг хичээж боловсруулсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтүүдээ батлах ёстой. 1990 онд эхэлсэн эрх зүйн шинэтгэл маань арай гэж цэгцэрч байна. Засаглалын шинэ хэлбэр хөөж, хэдэн зуун хууль, журмыг

дахиж бичих цаг, мөнгө бидэнд байхгүй. Шийдэх ёстой жинхэнэ асуудлууд, хийх ёстой ажлууддаа л төвлөрөе. Ажилгүй залуучууд, үнэн логикгүй цалин хөлс, орлогын тэгш бус байдал, бизнесийн орчин, стратегийн үйлдвэр, дэд бүтцүүд, орчны бохирдол, эрүүл мэндийн үйлчилгээ, ирээдүй үеийнхээ боловсролд анхааръя. Нэг хүнд эрх мэдлийг төвлөрүүлэхэд бидний геополитикийн нөхцөл тун эмзэг. Төвийг сахисан, эвсэлд үл нэгдэх гадаад бодлогоо тууштай сахиж, цөмийн зэвсэггүй бүсийн статусаа бэхжүүлэе.

Ерөнхийлөгчийн засаглалыг тууштай эсэргүүцэж энэ нийтлэлийг бичихдээ уншигч таныг түгшээх зорилго агуулаагүй гэдгээ зориуд сануулья. Тэгэх аваас нийгэмд айдас, бухимдал төрүүлж, үүссэн сэтгэл хөдлөлөөр далимдуулан, эрх ашгаа урагшлуулдаг шалихгүй улс төрчөөс ялгаагүй болно. Дарангуйллын давалгаа бодитой хэдий боловч дэлхийн улс орнуудын 2/3 нь ардчилсан

дэглэмтэй хэвээрээ байгаа. 2018 онд Малайз, Армен, Этопи, Ангол, Эквадор улсууд засгаа нээлттэй, ардчилсан болгох шийдвэртэй алхмууд хийснийг Freedom House онцлож байна. Нийгмийн шударга бус байдлыг илтгэсэн, олон нийтийг цочроосон мэдээ, баримт задрах тусам хийрхэж савлахгүйгээр, үйл явцыг саруул ухаанаар шүүн тунгаахыг танаас хүсье. Жаран тэрбумыг сонсоход, сэжигтнүүдийг эрүүдэн шүүхэд, мөнгөтэй оймс харахад ой гутаж байсан. Гэвч эдгээр баримтуудыг задлахад хүргэсэн ямар эрх ашиг, улс төр байгааг бид мэдэхгүй. Энд нэг л зүйл ойлгомжтой. ТАНД ЭРХ МЭДЭЛ БАЙНА! Танд эрх мэдэл байгаа учраас, таны үзэн ядалт, таны үгс хэрэгтэй учраас талцсан улс төрчид аргаа барахдаа танд хандаж байна. Эрх мэдэл нэг хүнд төвлөрчихвөл харин та хэрэггүй болно. “Их хүссэн хүнд төрийн жолоо бүү атгуул” гээд байлуу?

2019 оны 10-р сар

- ¹ Өгүүлэл интернетэд нээлттэй бий. Anna Lührmann and Staffan I. Lindberg 'A third wave of autocratization is here: What is new about it?' (2019) 26 Democratization 7, 1095-1113 <<https://www.tandfonline.com/doi/full/10.1080/13510347.2019.1582029>>.
- ² Francis Fukuyama, 'The End of History and the Last Man' (1992, Free Press). Фукуяма профессор хүйтэн дайн төгсөж, улс төрийн чөлөөт ардчилсан дэглэм дэлхийн жишиг боллоо хэмээн дүгнэсэн нь их алдаршсан.
- ³ Andrea Cassani and Luca Tomini, 'Post-Cold War autocratization: Trends and patterns of regime change opposite to democratization' (2019) 49 Italian Political Science Review/Rivista Italiana di Scienza Politica 121-138.
- ⁴ Stephen G.F. Hall and Thomas Ambrosio, 'Authoritarian Learning: A conceptual overview' (2017) 33 East European Politics 2, 143-161.
- ⁵ Steven Levitsky and Daniel Ziblatt, 'How Democracies Die: What History Reveals About Our Future' (2018, Crown Publishing). 2018 онд хэвлэгдсэн даруйдаа энэ ном нонфикшн жанрын номонд олгодог АНУ-ын ихэнх шагналыг түүсэн.
- ⁶ Нийтлэлд дурдагдсан баримтуудын ихэнхийг Левицки, Зиблатт нарын дээрх номноос дэлгэрүүлж уншиж болно.
- ⁷ Нийтлэлийн эхний хэсэгт өгүүлсэн нийгмийн суурь соёлоос гадна АНУ-ын улс төрийн хоёр бичигдээгүй дүрмийг ардчилсан засгийн баталгаа гэж үздэг. Mutual toleration буюу өрсөлдөгчөө хүлээн зөвшөөрөх гэдэг нь хуулийн дагуу өрсөлдөж байгаа тохиолдолд улс төрийн өрсөлдөгчийнхөө оршин байх, өрсөлдөх, засаглах эрхийг хүлээн зөвшөөрнө гэсэн агуулгатай. Institutional forbearance гэдэг нь хэдийгээр хуулиар эрх мэдэл олгогдсон боловч ардчилсан тогтолцоог сулруулах үйлдэл хийхээс зайлсхийх ёстой гэсэн агуулгатай.

EVSEG

Mongolian Premium Cashmere



СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНД ЭВСЭГ-ИЙН ЦЭГ НЭЭГДЛЭЭ

Утас: 11 343595, 9995 3027